



Батлав: Төмөр Замын Дээд Сургуулийн

ТЗДС/

Захирал

проф.Б.Сэрвүүд

ТЗДС-ын 60 жилийн ойн нэрэмжит

Метал судлалын улсын IV олимпиадын удирдамж

2013.02.25

Нэг. Олимпиадын зорилго

1.1 Монголын их, дээд сургуулиудад инженер, технологийн чиглэлээр бакалаврын шатанд суралцаж байгаа оюутнуудын материал болон метал судлалын шинжлэх ухааны мэдлэг чадварыг улам сайжруулах, сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлж онолын мэдлэгээ практикт ашиглах чадварыг нэмэгдүүлэх, улс орны өнөө, ирээдүйн шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Олимпиадын зохион байгуулалт

2.1 Олимпиадыг ТЗДС дээр тус сургуулийн 60 жилийн ойн нэрэмжит болгон зохион байгуулна. Олимпиадад материал болон метал судлалын хичээл заадаг Монгол улсын аль ч их, дээд сургууль оролцох эрхтэй. Олимпиадад 3 оюутан нэг баг болж орно. Нэг сургуулиас 1-2 баг оролцож болно.

2.2 Оролцох сургууль бүр асуулт бодлогоо Articulate Quizmaker болон Microsoft Office word программ дээр (*.docx өргөтгөлтэйгээр Times New Roman фонт, 10 pt үсгийн өндөртэй, зургийг JPEG, томъёог JPEG форматын зургаар файл хэлбэрээр) бэлтгэж 2013 оны 04-р сарын 20-ны өдрийн 7.00 цагт ТЗДС-ийн хичээлийн 1-р байрны 207 тоот өрөөнд авч ирнэ. Олимпиадад санал болгож буй материал нь **эгэл, үндсэн, асуудал шийдвэрлэх** гэсэн 3 хэсгээс тогтох бөгөөд **эгэл хэсэг** 40 асуулттай- зөв хариулт бүр 1 оноо, **үндсэн хэсэг** 50 асуулттай зөв хариулт бүр 2 оноо, **асуудал шийдвэрлэх хэсэг** 6 бодлого –зөв хариулт бүр 10 оноо, нийт оноо 200 байна.

2.3 Олимпиадад оролцох сургууль бүрээс нэг багш 2013 оны 04-р сарын 20-ны өдрийн 7.00 цагт ТЗДС-ийн хичээлийн 1-р байрны урлаг зааланд цуглаж сургууль тус бүрээс бэлтгэж ирсэн материалыг нягтлан үзэж шаардлага хангасан материалыг сонгон авч компьютерт суулгахад бэлтгэнэ.

2.4 Файл хэлбэрээр бэлтгэсэн материалыг ТЗДС-иас олимпиад зохион байгуулахаар томилогдсон багш нарт өгч 9.00 -9.30 цагт олимпиад явагдах өрөөний компьютерүүдэд суулгана.

2.5 Оролцогч талууд олимпиадыг дээд зэргийн зохион байгуулалттай, үнэнч шударга явуулахын төлөө эрх тэгш хамтран ажиллана.

2.6 Олимпиадын явцад журам дэг зорчсон оролцогчид ёс зүйн хариуцлага тооцож сургуулийн захиргаанд нь мэдэгдэх хүртэл арга хэмжээ авна.

2.7 Олимпиад ТЗДС-ийн Хичээлийн 1-р байрны 2-р давхарт хурлын зааланд 2013 оны 4-р сарын 20-ны 10.00-12.00 цаг хүртэл явагдана.

2.8 Олимпиадад оролцох хураамж нэг баг 200 000 төг байна. Хэрэв нэг сургуулиас хоёр баг орох бол хоёр дахь багийн хураамж 300 000 төг байна. Хураамжийг 2013 оны 03-р сарын 31-ний дотор ТЗДС-ийн дансанд шилжүүлсэн байна.

2.9 Оролцох баг мэдүүлгээ 2013 оны 4-р сарын 11-ний өдөр факс: 976-11-244270,

E-mail info@mrwi.mn хаягаар явуулна.

2.10 Орон нутгаас оролцогчдын байр, хоолны зардал хураамжиндаа багтах бөгөөд замын зардлыг өөрсдөө хариуцна.

2.11 Харилцах данс: Улаанбаатар хот, Худалдаа хөгжлийн банк, 805-р салбар 405011048

2.12 Холбогдох хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, Энх тайвны өргөн чөлөө-44, Төмөр Замын Дээд Сургууль, ш/х-76

Утас: 976-11-244264, 99030511, 99182066

Факс: 976-11-244270

E-mail: info@mrwi.mn

Гурав.Олимпиадын шагнал урамшуулал

А. Хувийн амжилтаар

- 1-р байр 1, диплом, алтан медаль, 350 000 төгрөг
- 2-р байр 1, диплом, мөнгөн медаль, 250 000 төгрөг
- 3-р байр 1, диплом, хүрэл медаль, 150 000 төгрөг

Б. Багийн дүнгээр

- 1-р байр 1, өргөмжлөл, алтан медаль, 400 000 төгрөг
- 2-р байр 1, өргөмжлөл, мөнгөн медаль, 300 000 төгрөг
- 3-р байр 1, өргөмжлөл, хүрэл медаль, 200 000 төгрөг

В. Аварга багийн багш - өргөмжлөл, медаль, 200 000 төгрөг

Зохион байгуулах комисс
ТЗДС-ийн захиргаа



Батлав: Төмөр Замын Дээд Сургуулийн

Захирал

проф. Б.Сэрвүүд

27/02/13

ТЗДС/

ТЗДС-ын 60 жилийн ойн нэрэмжит Метал судлалын улсын IV олимпиадын төлөвлөгөө

2013.02.25

№	Хийх ажил	Хугацаа	Хаана	Хариуцах эзэн
1	Оролцогч сургуулиудын метал судлалын багш нарын бэлтгэж ирсэн материалыг хянан шүүх	IV/20 07:00-09:00 цаг	ТЗДС-ийн хичээлийн I байрны урлаг зааланд	Оролцогч сургуулиудын метал судлалын багш нар
2	Оролцогч сургуулиудын бэлтгэж ирсэн олимпиадын асуултыг компьютерт оруулах, ажиллагааг шалгах	IV/20 09:00-09:40	--"	Шаравжамц Б.Баасанням Ч.Баярцэцэг Мөнхбаяр Ж.Отгонжаргал М.Бямбасүрэн Энхтөгс
3	Олимпиадад оролцогчдыг бүртгэх	IV/20 09:20-09:40	Хичээлийн I байрны вестибюльд	Б.Ариунболор Б.Энхжаргал Сугармаа
4	Оролцогчдын иргэний үнэмлэх, оюутны үнэмлэх, мандатыг шалгаж олимпиад явагдах өрөөнд оруулах, суудлыг сугалаагаар хувиарлах	IV/20 09:40-09:50	Хичээлийн I байрны урлаг зааланд	Мөнхбаяр Ж.Отгонжаргал Энх-Амгалан
5	Оролцогчдод олимпиадын дүрмийг танилцуулах	IV/20 09:50-10:00	--"	М.Бямбасүрэн
6	Олимпиадын явц	IV/20 10:00-12:00	--"	Камерын хяналт
7	Олимпиадын шүүгч, ажиглагч багш нарт цай, кофе, ундаа, цэвэр ус, хөнгөн зуушаар үйлчлэх	IV/20 07:00-12:00	Хичээлийн I байрны урлаг заал, № 207	Б.Ариунболор Б.Энхжаргал Сугармаа
8	Телевизийн бичлэг, дурсгалын зураг /олимпиадын явц, ТЗДС-ийн гадаа/	IV/20 11:00-12:30	ТЗДС	Майдар Энх-Амгалан
9	Оюутнуудад цай, кофе, бутербродоор үйлчлэх	IV/20 12:30-12:50	Хичээлийн 1-р байрны вестибюлд	Б.Ариунболор Б.Энхжаргал Сугармаа
10	Оюутнуудыг сургуультай танилцуулах	IV/20 12:50-13:30	ТЗДС	П.Нямсүрэн
11	Олимпиадын хаалт, сургуулийн баримтат кино үзүүлэх, шагнал гардуулах ёслол	IV/20 13:30-14:10	Хичээлийн I байрны урлаг заал	Б.Сэрвүүд П.Нямсүрэн П.Баясгалан Ж.Энхтайван
12	Өдрийн хоол, Зүтгүүрийн депо, УБТЗ-ын техникийн музей үзэх	IV/20 14:10-18:00	Зүтгүүрийн депо, музей,	Мягмар
13	Хүлээн авалт / Багш нар/	IV/20 14:10-15:30	Ган зам ресторанд	Б.Сарантуяа

Төлөвлөсөн багш: П.Баясгалан П.Баясгалан